



Хотын Засаглалыг Сайжруулах Төсөл



1990-ээд оноос хойш Монгол улсад улс төрийн болон эдийн засгийн томоохон өөрчлөлт, шинэчлэлүүд хийгдэж байна. Монгол уул уурхайд түшиглэсэн эдийн засагтай хэдий ч ядуурлын хэмжээ гэр хороололд өндөр байсаар байна. 2015 оны байдлаар Монгол улсын нийт хүн амын тал хувь нь буюу 1.4 сая орчим хүн Улаанбаатар хотноо амьдарч байна. Орон байрны хангамж, суурьшлын бүсийн хүрэлцээгүй байдал зэргээс шалтгаалан Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн дийлэнхи нь гэр хороололд суурьшиж, төлөвлөлтгүй гэр хорооллын хүрээг тэлсээр байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр Азийн сан Хотын Засаглалыг сайжруулах төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн гол зорилго нь **орон нутгийн түвшинд засаглал, удирдлагыг бэхжүүлж, ардчилсан, нээлттэй, ил тод засаглалын зарчмуудыг дэмжин, иргэд сонгогчдын өмнө хариуцлагатай байж, тэдгээрийг тогтвортой, найдвартай үйлчилгээгээр хангахад орон нутгийн удирдлагад дэмжлэг үзүүлэх явдал юм.** Уг төсөл нь Улаанбаатар хотын есөн дүүргийн, 33 гэр хороонд 330,000 гаруй иргэд, оршин суугчдыг хамруулан хэрэгжиж байна. Эрүүл аюулгүй байдлын индексийн гол үзүүлэлт болох хүрээлэн буй орчин болон дэд бүтэц, нийгмийн болон хүний хөгжил, эдийн засаг болон засаглалын үзүүлэлтээр 2014 онд “Хангалтгүй” үнэлгээ авсан хороодыг сонгон авч төсөлд хамруулсан.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ХҮРЭХ ҮР ДҮН

ҮР ДҮН

Төслийн гол үр дүнг **Улаанбаатар хотын захиргаа болон харьяа орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын аливаа бодлогыг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх**

чадавхи сайжирч, иргэдийн санал, оролцоон дээр үндэслэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, үйлчилгээг сайжруулах чиглэлийн шийдвэрийг гарган хэрэгжүүлдэг болох явдал юм.

- иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр шинэлэг арга, аргачлалыг хэрэгжүүлж иргэдийн оролцоог бодитойгоор нэмэгдүүлнэ.
- гэр хорооллын иргэдэд нэн тэргүүнд сайжруулах шаардлагатай байгаа үйлчилгээг иргэдийн оролцоотойгоор тодорхойлж өрсөлдөөнт аргаар жижиг төслүүдийг санхүүжүүлнэ.
- орон нутгийн засаг захиргааны байгууллагуудтай харилцах, шаардлагатай мэдээллийг авах чиглэлээр гэр хорооллын иргэдийн чадавхийг бэхжүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан туршилтын байдлаар хэрэгжүүлнэ.
- орон нутгийн түвшинд илүү ил тод, хариуцлагатай, иргэдийн оролцоонд тулгуурласан засаглалыг бэхжүүлэх чиглэлээр төрийн албан хаагчдыг чадавхижуулах сургалтын багц хөтөлбөрийг боловсруулна (иргэдийн болон орон нутгийн удирдлагуудын чадавхийг сайжруулах хөтөлбөрийг институцчилнэ).

ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД

ИРГЭДИЙН ОРОЛЦООТОЙ ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦИЙГ ДЭМЖИХ

Орон нутгийн хөгжлийн сангийн (ОНХС) үйл явцад шинэлэг оролцооны аргачлалыг нэвтрүүлэх, шинэ техник, технологийг турших, үйл явцыг нээлттэй ил тод болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилтыг тавин ажиллаж байна.

2013 оны 1-р сард хэрэгжиж эхэлсэн Төсвийн тухай хуулиар ОНХС-аар төслүүд хэрэгжүүлэх эрх мэдлийг тухайн орон нутагт өгсөн ба шийдвэр гаргах үйл явцад иргэдийн саналыг авахаар тусгаж өгсөн билээ. Төслийн нэгжтэй хамтран ажиллаж буй Нээлттэй Нийгэм Хүрээлэн ОНХС-аар хэрэгжих төслүүдэд иргэдээс санал авах хуудсыг боловсронгуй болгох, шинэчлэн сайжруулах ажлыг хийж байна. “Гэр - Иргэдийн оролцоотой газрын зураглал” төв нь ОНХС-аар хэрэгжиж байгаа төслүүдийг болон тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдэд хамрагдах төслийн хороодын зорилтот бүлгийн нарийвчилсан мэдээллийг газрын зураглалд буулгах ажлыг хийж байна.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

Гэр хорооллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхээр Төслийн нэгжийн зүгээс хороодтой нягт хамтран ажиллаж байна. Төсөлд хамрагдаж буй 33 хороонд “Иргэдийн онооны карт”-ыг хэрэгжүүлж иргэдэд нэн шаардлагатай, сайжруулах үйлчилгээг эрэмбэлэхэд ус болон усны аюулгүй байдал, нийтийн тээвэр, цахилгаан, хатуу хог хаягдал, хот төлөвлөлт, гудамжны гэрэлтүүлэг, газар, эрүүл мэнд болон нийгмийн халамжийн үйлчилгээнүүд орсон байна. Иргэдэд ээлтэй үйлчилгээг сайжруулах жижиг тэтгэлэгийн хүрээнд тухайн хороодын иргэд, хороог оролцуулсан хамтран ажиллах төлөвлөгөөг гарган үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад тухайн үйлчилгээг сайжруулах чиглэлийн төслүүдийг хэрэгжүүлээ.

ИРГЭДИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ

Төсөлд хамрагдаж буй хороодын өрхүүд болон иргэд хооронд мэдээлэл солилцох, цаашилаад мэдээлэл дутмаг өрхүүдэд шаардлагатай мэдээллийг хүргэх, иргэдийг чадавхжуулахаар хороодтой хамтран ажиллаж байна. Төслийн хамтран ажиллагч байгууллага болох Нээлттэй Нийгмийн Хүрээлэн иргэдийн оролцоо болон орон нутгийн засаглалд хэрхэн идэвхитэй оролцох талаар Иргэдийн гарын авлагыг боловсруулан ажиллаж байна.

Энэхүү гарын авлагыг иргэдийг чадавхижуулах зорилгоор идэвхитэй иргэд болон хэсгийн ахлагч нарыг сургагч багш болгох сургалтанд ашиглана. Гэр хорооллын иргэдэд хамгийн оновчтой аргаар хүрэх тухайн орон нутгийн онцлогт тохирсон сургалтуудыг төслийн хугацаанд тогтмол явуулах юм.


ТӨРИЙН БАЙГУУЛАГЫН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ

Улаанбаатар хотын захиргааны (хороо, дүүрэг, хот) чадавхийг бэхжүүлэх өргөн хүрээний цогц хөтөлбөрийг боловсруулж, иргэдийн оролцоог хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг орон нутгийн түвшинд бий болгоход нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр Төслийн нэгж ажиллаж байна. Төслийн түнш байгууллага Транспаренс Интернейшнл-Монгол байгууллагаас хэсгийн ахлагч нарт зориулсан мэргэжлийн ур чадвар, ажлын байранд тавигдах шаардлага, хувь хүний болон нийгмийн чадавхи дээшлүүлэх сургалтын модулийг боловсруулан гаргасан ба цахим хувилбарт шилжүүлэх ажлыг Төслийн нэгж удахгүй эхлүүлнэ.

ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ИНСТИТУЦЛАХ

Төрийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, хотын захиргааны албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх сургалтын болон сертификатын хөтөлбөрийг төслийн хугацаанд болон төсөл дууссаны дараа тогтмол явуулах, нийслэлийн төсөвт тусган санхүүжүүлэх, мэргэжлийн хөгжлийн соёлыг бий болгоход Төслийн нэгжийн зүгээс анхаарал хандуулан ажиллана. Түүнчилэн хотын захиргаатай тогтмол хамтран ажилласнаар бүх шатны төрийн албан хаагчид болон иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг хотын захиргааны салшгүй нэг хэсэг болгохоор зорьж байна.

Азийн Сан нь ашигийн бус, төрийн бус, олон улсын хөгжлийн байгууллага бөгөөд АНУ-ын Сан Франциско хотод төвтэй, Азийн 18 орон болон АНУ-ын Вашингтон Ди Си хотод салбаруудтай. Төр, хувийн хэвшил, олон нийтийн байгууллагуудтай хамтран засаглал, эдийн засгийн хөгжил, эмэгтэйчүүдийг чадавхижуулах, байгаль орчныг хамгаалах, бус нутгийн хамтын ажиллагааг дэмжих зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



The Asia Foundation
Improving Lives, Expanding Opportunities

Төв байр
465 Калифорни гудамж, 9-р давхар, Сан Франциско хот, СА 94104 АНУ
Утас (415) 982-4640
Факс: (415) 392-8863

Монгол дахь суурин төлөөлөгчийн газар
Ориент Плаза, 3-р давхар
Г.Чагдаржавын гудамж
Төв шуудан, ш/х 1003
Улаанбаатар хот, 14210
Монгол улс
Утас: 976-11-330524
www.asiafoundation.org

ХОТЫН ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн үргэлжлэх хугацаа: 2015 оны 7 дугаар сараас 2018 оны 12 дугаар сар

Хамтран ажиллагч байгууллагууд: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нээлттэй нийгмийн хүрээлэн, Транспаренс Интернейшнл-Монгол, Ардчиллын Боловсролын Төв

Санхүүжүүлэгч: Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөрийн II шатны хүрээнд Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр НЗДТГ-тай хамтран ажиллаж байна.